



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/104/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Архангай аймаг

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Азхүү

Цахим хаяг: azkhuub@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа. /Local.audit.mn сайтад шивсэн/	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН ХАНГАЙ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Я.БАЯСГАЛАН ТАНАА

2022.01.25 № 119
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангай сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангай сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021.12.31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	68,984,478.68	217,900,749.17
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	5,385,808.72
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	5,385,808.72
31210	Төгрөг	0.00	5,385,808.72
31211	Төрийн сангийн харилцах	0.00	4,112,766.32
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	1,273,042.40
33	АВЛАГА	0.00	44,004,400.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	44,004,400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	68,984,478.68	168,510,540.45
35100	Түүхий эд материал	48,443,297.48	144,227,938.25
35110	Тусгай зориулалттай материал	10,465,581.75	45,654,641.98
35130	Эм боох материал	37,977,715.73	98,573,296.27
35400	Хангамжийн материал	20,541,181.20	24,282,602.20
35410	Бичиг хэргийн материал	1,622,277.00	2,096,377.00
35420	Аж ахуйн материал	16,875,043.70	19,862,943.70
35440	Түлш, шатах тослох материал	1,726,000.00	1,360,000.00
35460	Хүнсний материал	317,860.50	788,281.50
35470	Бусад хангамжийн материал	0.00	175,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	577,756,377.74	578,673,650.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	577,756,377.74	578,673,650.37
39200	Биет хөрөнгө	570,268,877.70	571,311,150.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	410,203,419.24	410,203,419.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	-14,754,957.48	-16,634,743.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	207,066,462.21	207,066,462.21
39204	Хуримтлагдсан элэгдэл	-68,624,880.57	-75,417,439.62
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	115,327,803.70	127,331,507.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-83,248,944.27	-85,304,732.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,570,439.40	11,570,439.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,302,464.53	-7,535,761.62
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,509,408.98	3,509,408.98
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,477,408.98	-3,477,408.98
39300	Биет бус хөрөнгө	7,487,500.04	7,362,500.06
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-812,499.96	-937,499.94
39303	Бусад биет бус хөрөнгө	6,800,000.00	6,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	646,740,856.42	796,574,399.54
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	646,740,856.42	796,574,399.54
51	Засгийн газрын хувь оролцоо	646,740,856.42	796,574,399.54
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	611,535,526.03	611,535,526.03
51200	Хуримтлагдсан үр дүн	-15,714,983.32	134,118,559.80
51210	Өмнөх үеийн үр дүн	-169,036,311.93	-15,714,983.32
51220	Тайлант үеийн үр дүн	153,321,328.61	149,833,543.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	50,920,313.71	50,920,313.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	646,740,856.42	796,574,399.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	664,877,596.68	980,087,896.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	180,670,796.68	230,334,476.11
120	Нийтлэг татварын бус орлого	180,670,796.68	230,334,476.11
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	144,795,549.00	12,003,703.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	35,875,247.68	218,330,772.55
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	484,206,800.00	749,753,420.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	432,381,300.00	487,297,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	432,381,300.00	487,297,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,222,550.00	218,669,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,222,550.00	174,665,300.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00	44,004,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14,995,700.00	16,150,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,995,700.00	16,150,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	32,607,250.00	27,636,720.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,607,250.00	27,636,720.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	511,556,268.07	830,254,352.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	511,556,268.07	830,254,352.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	511,024,240.66	793,854,352.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	325,545,993.59	431,755,732.62
210101	Үндсэн цалин	214,920,655.00	203,014,353.66
210102	Нэмэгдэл	82,739,338.59	153,561,178.96
210104	Урамшуулал	21,550,000.00	41,700,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	33,480,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,881,800.00	48,314,129.66
210201	Тэтгэврийн даатгал	31,540,365.00	33,686,244.77
210202	Тэтгэмжийн даатгал	3,250,500.00	3,782,087.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,939,835.00	3,550,985.84
210204	Ажилгүйдлийн даатгал	1,143,410.00	872,769.13
210205	Эрүүл мэндийн даатгал	6,007,690.00	6,422,042.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,944,579.00	15,133,099.00
210301	Гэрэл, цахилгаан	4,987,419.00	4,674,735.00
210302	Түлш, халаалт	8,912,160.00	10,386,000.00
210303	Цэвэр, бохир ус	45,000.00	72,364.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,873,290.00	39,801,700.00
210401	Бичиг хэрэг	2,562,800.00	3,078,550.00
210402	Тээвэр, шатахуун	22,809,900.00	29,656,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,700,000.00	1,886,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	859,800.00	325,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,330,200.00	1,462,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	3,392,750.00
2105	Нормативт зардал	26,482,832.78	239,085,350.78
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,841,089.28	225,618,441.78
210502	Хоол, хүнс	4,641,743.50	12,846,909.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	620,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	477,000.00	3,185,000.00
210604	Урсгал засвар	477,000.00	3,185,000.00

2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	2,900,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	2,900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,204,759.00	787,910.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	40,000.00	80,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	105,910.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	352,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,813,986.29	12,891,430.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,717,873.00	1,805,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,096,113.29	11,086,430.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	532,027.41	36,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	36,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	36,400,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	532,027.41	0.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	532,027.41	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	153,321,328.61	149,833,543.12
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	153,321,328.61	149,833,543.12

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	611,535,526.03	50,920,313.71	-15,714,983.32	646,740,856.42
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	611,535,526.03	50,920,313.71	-15,714,983.32	646,740,856.42
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	611,535,526.03	50,920,313.71	-15,714,983.32	646,740,856.42
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	149,833,543.12	149,833,543.12
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	611,535,526.03	50,920,313.71	134,118,559.80	796,574,399.54

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	484,206,800.00	705,749,020.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	484,206,800.00	705,749,020.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	432,381,300.00	487,297,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	432,381,300.00	487,297,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,222,550.00	174,665,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,222,550.00	174,665,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14,995,700.00	16,150,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,995,700.00	16,150,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	32,607,250.00	27,636,720.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	32,607,250.00	27,636,720.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	482,889,800.00	700,363,211.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	482,889,800.00	700,363,211.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	482,357,772.59	663,963,211.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	324,845,993.59	429,428,319.74
210101	Үндсэн цалин	215,500,000.00	203,014,353.66
210102	Нэмэгдэл	80,931,993.59	151,233,766.08
210104	Урамшуулал	21,550,000.00	41,700,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	33,480,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,881,800.00	50,641,542.54
210201	Тэтгэврийн даатгал	30,879,800.00	36,013,657.65
210202	Тэтгэмжийн даатгал	3,250,500.00	3,782,087.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,600,400.00	3,041,410.71
210204	Ажилгүйдлийн даатгал	650,100.00	872,769.13
210205	Эрүүл мэндийн даатгал	6,501,000.00	6,931,617.19
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,720,579.00	16,493,099.00
210301	Гэрэл, цахилгаан	4,987,419.00	6,000,000.00
210302	Түлш, халаалт	8,688,160.00	10,420,735.00
210303	Цэвэр, бохир ус	45,000.00	72,364.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,859,900.00	35,589,700.00
210401	Бичиг хэрэг	2,300,000.00	2,300,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,809,900.00	26,539,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,700,000.00	2,076,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	1,124,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,550,000.00	3,550,000.00
2105	Нормативт зардал	21,999,200.00	80,442,620.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,255,250.00	66,984,820.00
210502	Хоол, хүнс	4,053,600.00	12,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,690,350.00	957,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,049,800.00	37,238,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	34,738,800.00
210604	Урсгал засвар	1,049,800.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	2,900,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	2,900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,170,600.00	847,910.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,070,600.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	40,000.00	80,000.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	105,910.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	412,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,029,900.00	10,381,220.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,029,900.00	10,381,220.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	532,027.41	36,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	36,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	36,400,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	532,027.41	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,317,000.00	5,385,808.72
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,317,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,317,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,317,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,317,000.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,317,000.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	5,385,808.72
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	5,385,808.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	537,447,000.00	526,970,953.68	10,476,046.32	98.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	537,447,000.00	526,970,953.68	10,476,046.32	98.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	537,447,000.00	526,970,953.68	10,476,046.32	98.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	385,680,200.00	385,456,746.14	223,453.86	99.94
210101	Үндсэн цалин	215,500,000.00	201,883,756.74	13,616,243.26	93.68
210102	Нэмэгдэл	95,000,000.00	108,392,789.40	13,392,789.40	114.10
210104	Урамшуулал	41,700,000.00	41,700,000.00	0.00	100.00
210105	Гэрээт ажлын хөлс	33,480,200.00	33,480,200.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,066,800.00	50,641,542.54	1,425,257.46	97.26
210201	Тэтгэврийн даатгал	36,639,600.00	36,013,657.65	625,942.35	98.29
210202	Тэтгэмжийн даатгал	3,856,800.00	3,782,087.86	74,712.14	98.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,085,400.00	3,041,410.71	43,989.29	98.57
210204	Ажилгүйдлийн даатгал	771,400.00	872,769.13	-101,369.13	113.14
210205	Эрүүл мэндийн даатгал	7,713,600.00	6,931,617.19	781,982.81	89.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,650,000.00	13,493,099.00	156,901.00	98.85
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.00
210302	Түлш, халаалт	9,000,000.00	8,920,735.00	79,265.00	99.12
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	72,364.00	77,636.00	48.24
2104	Хангамж, бараа материалын зардал	32,550,000.00	32,550,000.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	2,300,000.00	2,300,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	23,500,000.00	23,500,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,700,000.00	2,076,000.00	-376,000.00	122.12
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,124,000.00	376,000.00	74.93
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,550,000.00	3,550,000.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	34,000,000.00	26,094,520.00	7,905,480.00	76.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,000,000.00	17,636,720.00	6,363,280.00	73.49
210502	Хоол, хүнс	7,500,000.00	7,500,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	957,800.00	1,542,200.00	38.31
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	5,991,405.00	8,595.00	99.86
210601	Багаж, техник хэрэгсэл	3,500,000.00	3,491,405.00	8,595.00	99.75
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	3,300,000.00	2,900,000.00	400,000.00	87.88
210702	Дотоод албан томилолт	3,300,000.00	2,900,000.00	400,000.00	87.88
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200,000.00	847,910.00	352,090.00	70.66
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	80,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	105,910.00	14,090.00	88.26

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	412,000.00	338,000.00	54.93
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,000,000.00	8,995,731.00	4,269.00	99.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,000,000.00	8,995,731.00	4,269.00	99.95
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	537,447,000.00	531,083,720.00	6,363,280.00	98.82
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	487,297,000.00	487,297,000.00	0.00	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00	0.00	#DIV/0!
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	487,297,000.00	487,297,000.00	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	16,150,000.00	16,150,000.00	0.00	100.00
320001	Орон нутгийн төсвөөс	16,150,000.00	16,150,000.00	0.00	100.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,000,000.00	27,636,720.00	6,363,280.00	81.28
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	34,000,000.00	27,636,720.00	6,363,280.00	81.28
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	26	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20	20	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26	26	0.00	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	21	21	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	0.00	100.00

2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	173,392,257.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	173,392,257.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	136,992,257.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,971,573.60
210101	Үндсэн цалин	1,130,596.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	
210201	Тэтгэврийн даатгал	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,000,000.00
210301	Гэрэл цахилгаан	1,500,000.00
210302	Түлш халаалт	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,039,700.00
210401	Бичиг хэрэг	
210402	Тээвэр, шатахуун	3,039,700.00
210403	Шуудан холбоо, интернетийн төлбөр	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	
2105	Нормативт зардал	54,348,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,348,100.00
210502	Хоол, хүнс	5,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,247,395.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,247,395.00
210604	Урсгал засвар	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,385,489.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,385,489.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	36,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	
2200	Дотоод эх үүсвэрээр	
222001	Тоног төхөөрөмж	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	174,665,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	174,665,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	174,665,300.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	1273042.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1273042.4

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах удитор Б.Азхүү гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хангай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хангай сумын Эрүүл мэндийн төв нь нийгмийн болон эмнэлэгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайлант онд *“Хүн амд яаралтай тусламжийн үйлчилгээг цаг алдалгүй мэргэжлийн түвшинд чадварлаг жигд хүртээмжтэй үзүүлж, нотолгоонд суурилсан оновчтой, чанартай эмчилгээ үйлчилгээ үзүүлэх, хөрвөх чадвартай, ёс зүйг дээдэлсэн, эрүүл орчинд ажиллах, зөв зан үйлд суралцаж нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-иар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 67/А/268 дугаар тушаал “Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай”

- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/585 дугаар тушаал “Мөнгөн тэтгэмж олгох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хангай сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурель сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 537.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 3.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 149.8 сая төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	хувь
Мөнгөн хөрөнгө	0	5.3	5.3	
Авлага		44.0	44.0	
Бараа материал	68.9	168.5	99.6	144.5
Үндсэн хөрөнгө	577.8	578.7	0.9	0.1
Нийт хөрөнгө	646.7	796.5	149.8	23.1
Өр төлбөр	0	0	0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	646.7	796.5	149.8	23.16
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	646.7	796.5	149.8	23.16

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 5.3 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлдэг болсонтой холбоотой байна.
- Авлагын дансны үлдэгдэл тайлант онд 44.0 сая төгрөгөөр өссөн нь ЭМДС-аас авах ковидын цогц тусламж үйлчилгээний санхүүжилт нэхэмжилснээс дутуу ирсэнтэй холбоотой байа.
- Бараа материал эхний үлдэгдлээс 144.5 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 68.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 171.5 сая төгрөг, хандиваар 218.3 сая төгрөг нийт 389.7 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 290.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 168.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 23.1 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 577.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд хандиваар 12.0 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 11.1 сая төгрөгийн элэгдлээр буурч 578.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 149.8 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	180.7	230.3	49.6
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	432.4	487.3	54.9
Нэмэлт санхүүжилт	4.2	218.6	214.4
Орон нутгийн төсвөөс	14.9	16.2	1.3
Эрүүл мэндийн даатгалын сангаас	32.6	27.6	-5.0

Үйл ажиллагааны орлого	664.8	980.0	315.2
Цалин, шимтгэлийн зардал	369.3	480.0	110.7
Бараа ажил үйлчилгээний зардал	75.7	300.2	224.5
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38.2	0.8	-37.4
Бараа үйлчилгээний бусад зардал	27.8	12.8	-15.0
Урсгал шилжүүлэг	0.5	36.4	35.9
Хөрөнгийн зардал	-		
Үйл ажиллагааны зардал	511.5	830.2	318.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	153.3	149.8	-3.5

Хангай сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 315.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгож байгаатай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 553.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 16.3 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 537.4 сая төгрөгөөр хянаж баталсан бол тодотголоор батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 537.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 44.0 сая төгрөгийн санхүүжилт Эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу ирсэн байна. Тайлант онд 526.9 сая төгрөгийг зарцуулж, 5.3 сая төгрөгийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМДС-аас ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилт 173.3 сая төгрөг ирсэн байна. Ирсэн санхүүжилтийг зарцуулах эрхийн хүсэлт нээлгэн зарцуулсан байна. Үүнд:

цалин шимтгэлд 43.9 сая, тээвэр шатахуунд 3.0 сая, эм зардалд 49.3 сая, Бараа үйлчилгээний бусад зардалд 1.3 сая, хоол хүнсэнд 5.0 сая, багаж, техник хэрэгсэлд 31.2 сая, Түлш халаалт 1.5 сая, гэрэл цахилгаанд 1.5 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулалд 37.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хангай сумын Эрүүл мэндийн төв нь тайлант жилд ковид-19 халдварын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг нийт 288 хүнд үзүүлж ЭМДС-аас 184.5 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилж гүйцэтгэлээр 140.5 сая төгрөг авч оны эцэст 44.0 сая төгрөгийн авлагатай тайлагнасан.

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлж 5.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй үлдэгдлээр тайлагнасан бол ЭМГ-ын даргын 2021.08.25-ны өдрийн 02/849 дугаар тушаалын дагуу 98.5 сая төгрөгийн эмийн нөөцийг бүрдүүлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн ажилтнуудад нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 37.4 сая төгрөг олгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 7 үндсэн зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 91.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 537.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 98.5 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

- Тус байгууллага нь тайлант онд 218.3 сая төгрөгийн бараа материалыг аймгийн ЭМГ-аас, 12 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ЭМЯ-аас хандив тусламжаар авч тайланд бүрэн тусгасан байна.
- Ковид-19 халдвараар өвчилсөн 288 хүнд тусламж үйлчилгээ үзүүлж эмийн багцад 13.6 сая төгрөг, нэг удаагийн хамгаалах хэрэгсэлд 10.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.
- Тус байгууллага нь үндсэн орон тооны жолоочтой бөгөөд цалингийн зардалд 13.3 сая төгрөг олгосон байна. Тайлант онд 28.0 сая төгрөгийн балансын үнэтэй УАЗ-пургон авто машины шатахууны зардалд 6.9 сая төгрөг, 123.0 сая төгрөгийн балансын үнэтэй УАЗ-пургон авто машины шатахууны зардалд 14.1 сая төгрөг, 35.5 сая төгрөгийн балансын үнэтэй Ланд 105 маркын авто машины шатахууны зардалд 2.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа. /Local.audit.mn сайтад шивсэн/

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хангай сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд оруулбал зохих 144 мэдээллийг байршуулахаас 11 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Мөн өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 77.5 сая төгрөгийн 9 тушаал, шийдвэрийг системд байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж, хэрэгжилт хангалтгүй байгаа тул холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд дотоод хяналт болон тээвэр шатахууны хэтрэлт хэмнэлтийн тооцож, хяналтыг сайжруулах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгөтэй холбоотой 3 заалт бүхий зөвлөмж өгч биелэлтийг хангуулсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Нэмэлт санхүүжилт, хандив тусламжийн зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 153.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 153.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайлангийн тайлант үеийн үр дүн 153.3 сая төгрөгөөр илүү тайлагнасан алдааг аудитын явцад залрууллаа.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo---

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Хангай сумын ЭМТ	1	153.3	1	153.3						
	дүн	1	153.3	1	153.3						
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Хангай сумын ЭМТ										
	дүн										
	Нийт дүн	1	153.3	1	153.3						